

## **СЭТГЭЛ ЗҮЙН ТАЛААРХ ЖДЫЮИГИЙН ҮЗЭЛ САНААНААС**

**Ж.Каламхас (Докторант)  
ШУТИС-ийн ДаТС-ийн багш**

**Тулхүүр үсэг: боловсрол, сургалт, сонирхол, түриллага бодох үйлдэл**

**Гол утга:** Энэхүү өгүүлэлдээ прагматизмийн төлөөлөгч, орчин үеийн боловсролын философиийг үндэслэгч Америкийн философийн Жон Дьюигийн сурганы тулгуур асуудлуудын нэг болох сэтгэл зүйн үзэл санааны агуулгаас тусгахыг зорилго болгов.

Дэлхийн боловсролын хөгжлийн сэтгэлгээний агуулга нь нь хүн, нийгэмээ даган хувьсан өөрчлөгдөж, баяжсаар ирсэн түүхтэй. Өөрчлөлт шинэчлэлт бүхэн тэр бүр сайн нөлөө үзүүлдэггүй хэдий ч түүнээс гарах үр дүн нь өндөр байдаг жамтай.

Мэдээллийн эрэн үед боловсролын философиин агуулгыг танин мэдэж түүнд холбогдох үзэл санаа, онолыг судлаж, практикт турших нь сурган хүмүүжүүлэх ухааны чухал асуудлуудын нэг хэвээр байна. Боловсролын философи нь хүнд зөвхөн мэдлэг олгохоос гадна тэрхүү мэдлэгт агуулагдаж буй мөн чанар, утга агуулгыг зөв ойлгуулж эзэмшигүүлэх, суралцгачийн суралцгачийн чармайлалтыг нэмэгдүүлж, бүтээлч сэтгэлгээний дадал чадварыг нь хөгжүүлэх түүнчлэн хүмүүнлэг ардчилсан дэг ёсыг эрхэмлэсэн сургалтын аргыг хэрхэн бий болгох вэ? зэрэг асуудлуудыг багтаасан байдаг. Эдгээр асуудлуудын мөн чанарыг боловсролын философиийн судалгааны ном зохиолуудад илүү үндэслэлтэй нарийвчлан тайлбарласан байдаг.

Монголын боловсролын тогтолцоонд философиийн тогтсон үзэл баримтлал, чиг шугам үгүйгээс иргэд боловсролын талаар буруу ойлгох, өрөөсгөл хандлага их байгаа нь ажиглагдаж байна. Ийм учраас эл асуудлын үндсэн учир шалтгааныг судалж, иргэдийн боловсролыг ойлгох үнэлэмжийг дээшлүүлэх арга замыг хайж, түүнд холбогдох боловсролын философичдын сонгодог бүтээлүүдийг судалж, суралцах нь чухал ач холбогдолтой болоод байна.

19-р зууны эцсээр Америкт үүссэн прагматизмийн гол төлөөлөгч Ж.Дьюи нь 1859 онд мэндлэсэн бөгөөд түүнийг төрөх үед байгаль шинжээч Чарльз Дарвин “Зүйлийн үүсэл” зохиолоо хэвлүүлж байсан түүхтэй. Хожим нь судлаачид Ж.Дьюигийн боловсролын философиийн үзэлд Ч.Дарвина “Зүйлийн үүсэл” зохиол дахь эволюци сэтгэлгээ нь хүчтэй нөлөө үзүүлсэн гэж үздэг. Ж.Дьюи нь (1859-1952) философиийн бүхий л асуудлаар 30 орчим ном зохиол, боловсролын чиглэлээр 150 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн ба тэрээр эхлээд сэтгэл судлалын асуудлыг сонирхож байгаад улмаар шинэ маягийн заах арга бүхий сурганы ухааныг боловсруулсан нь “дэвшилтэг боловсрол” нэрээр алдаршжээ.

“Философидно гэдэг бол ертөнцийг хөндлөнгөөс ажиглах явдал биш, амьдралд идэвхитэй оролцох явдал”<sup>1</sup> гэж тэрээр тодорхойлжээ. Философиийн асуудлууд нь хүмүүсийн амьдралаас тусдаа байдаг хийсвэр зүйл биш, асуудал гэдэг бол хүмүүс өөрсдийнхөө амьдралыг угтажуулах, дээд зэргээр үйлдэх гэж оролддогоос үүдэлтэй зүйл. Философи нь хүмүүсийн өдөр тутмын итгэл найдвар, урам зориг, амьдралд дээр гарч буй асуудлаас үүсдэг гэж тэрээр үзсэн. Ж.Дьюигийн философиийн гол ойлголт нь хүний амьдралын үйл ажиллагааны гол хүчин

авч үзсэн. Философиин зорилго нь туршлагын ургал дунд хүн өөрийн өмнө тавьсан ямар нэг зорилгодоо хүрэхд нь туслах явдал. Гэхдээ хүний хувийн ямар нэг зорилго биш, харин туршлагыг хүний үл ажиллагааны бүхий л хүрээнд боловсронгуй болгох зорилго юм. Энэ утгаар Ж.Дьюи боловсролын системийг бүхэлд нь өөрчлөхийг хүссэн байна. Боловсролыг өөрчилсөнөөр нийгмийн амьдрал чөөрчлөгднө гэж үзжээ. Боловсрол гэдэг нь түүнийхээр хоосон ярьдаг асуудал биш харин бүтээлч, идэвхт үл явц юм. Боловсролыг түгээх үндсэн суурь нь сургууль. Сургууль бол амьдралд бэлтгэх үл ажиллагаа биш, амьдрал өөрөө мөн гэж Ж.Дьюи үзжээ. “Сургууль бол зөвхөн нас биед хүргэдэг газар бус, оюун ухааны тасралтгүй өсөлтийг хангадаг, амьдралын туршид үл тасрах гэрэл гэгээг өгдөг, хүүхдийн зорилго эрмэлзлийг нээж, хөгжүүлэх газар байх ёстой юм”<sup>2</sup> хэмээн тэрээр хэлжээ. Суралцагсдын толгойд гадаад мэдээлэл, мэдлэгийг суулгаж өгөх нь гол биш, харин тэдний өөрсдийнх нь авьяас чадварыг хөгжүүлэх нь чухал юм. Суралцагсдын авьяас чадварыг хөгжүүлэх чухал үндэс нь тэдгээрийн сэтгэл зүйг тодорхойлж, сургалтын үл ажиллагааг хөтөн чиглүүлэх нь үр дүнтэй гэжээ.

Ж.Дьюи нь трансцендент болоод бодит бус тайлбарлалуудыг хүлээн зөвшөөрдөггүй үзлээрээ бихевиорист мэт ойлгогдог хэдий ч, тэрээр өдөөгч-хариу сэтгэл зүйн үзлийг тодорхой эсэргүүцсэн юм. Уг сэтгэл зүй нь хүний бүхий л зан төлөв нь хүрээлэн буй орчны өдөөлтөнд нөхцөлт (эсвэл нөхцөлт бус) хариугаар тайлбарлагдах боломжтой гэж үздэг. Хүрээлэн буй орчин нь оюун ухаанд сэдэл өгч түүний үр дүнд аливаа юмыг танин мэддэг бөгөөд гадаад орчин бидний ухамсарт гол нелөө үзүүлдэг тиймээс бид түүнд захирагддаг. Бидний дундаас хэн нэг нь хүн төрөлхтөний сайн сайхны төлөө хүрээлэн буй орчныг зохицуулан ашиглах үнэхээр чадвартай байж магадгүй. Гэвч үүнийг хийх бидний хүч чадал нь өөрөө хариу үйлдэл болоод өдөөгчийн гинжийн үр дүн юм гэж үзжээ.

Ж.Дьюи эхэн үеийн эссэнүүдийнхээ нэгэнд “хүний бие махбод нь өдөөгчид бараг хариу үзүүлдэггүй харин өдөөгчийг идэвхтэйгээр сонгож, зорилго чиглэлдээ тохирсон байдлаар хариулдаг”<sup>3</sup> хэмээн бичсэн байдаг. Түүнийхээр суралцагчид нь (идэвхтэй организмийн хувьд) өөрсдийн зорилго болоод суралцах үл ажиллагааныхаа хоорондох холбоог ухамсарлаж чадваас түүнээс гарах үр дүн нь өндөр байдаг гэж үзжээ.

Ж.Дьюи нь “Хэрхэн бодох вэ?” нэртэй өгүүлэлдээ хүүхэд бол аливаа зүйлийн эхлэх цэг, гол төв, төгсгөл юм. Иймд түүний хөгжлийн хамгийн түрүүнд тооцох хэрэгтэй. Учир нь түүний хөгжил л хүмүүжлийн гол материал болдог хэмээн тэрээр бичсэн байна. Хүүхэд бүрийн дотоод сэтгэхүйн онцлог, мөн чанарыг танин мэдэж, түүний талаар тодорхой тайлбарлалыг дэвшүүлсэн. Хүүхэд өөрт тусгагдаж байгаа үзэгдлийг дууриах нь харагдаж байгаа шигээ хялбар юм биш гэж тайлбарласан. Хүүхэд зөвхөн дууриадаггүй. Энэ нь тэд бүх насанд хүрэгчдийн үйлдлийг дууриадаггүй гэдгийг ажигласаны үр дүнд батлагдах боломжтой. Тэд сонгодог. Тэд дууриах үедээ өөрсдийн зорилгод зан төлвийн тодорхой хэлбэрүүдийг ашигладаг. Эцгийнхээ будгаар будаж байгаа эсвэл алхаар цохиж байгааг дууриах бяцхан хүү нь ямар нэг зүйлийг гүйцэтгэн дуусгахыг оролдож байгаа юм. Хүүхэд адил хөдөлгөөнүүдийг харж гүйцэтгэж байгаа ч энэ гүйцэтгэл нь түүний өөрийн хүсэл зорилгод нийцсэн байдаг. Иймд дууриах гэдгийг “хөөрхөн” гэж үзэх эсвэл шоолох ёсгүй юм. Эдгээрийн ихэнх нь хүүхэд насан дахь жинхэнэ ажил юм.

Ж.Дьюи нь хүүхдийн гярхай ажиглагч байсан төдийгүй хүүхдийг нийгэм, соёл, шинжлэх ухаан зэрэг олон талт хүчин зүйлсийн хүчтэй нөлөөллийн объект болгох саналыг дэвшүүлж байв. Гэхдээ хүч хэрэглэсэн аргаар биш, түүний төрөлхийн сонирхол хэрэгцээнд тулгуурлан хүүхдийн хувийн туршлагыг тасралтгүй хувирган хөгжүүлэхэд оршино гээд “Сургууль ба Нийгэм” зохиолдоо, хүүхдийн дөрвөн талт сонирхлын тухай тайлбарласан. Үүнд:

1. Юм хийж, бүтээх (бүтээн босгох)
2. Олж мэдэх (асуух, судалгаанд татагдах)
3. Уран сайхны байдлаар өөрсдийгөө илэрхийлэх

2. J.Dewey, *School and Society* (University of Chicago Press, Chicago, 1990), p.75

3. Nel Noddings *Philosophy of education* (Westview Press., 2006), p.30

#### 4. Харилцаа холбоогоор холбогдох.

Олон сурган хүмүүжүүлэгчид, эдгээр дөрвөн сонирхолын иеоцийг бага сургуулийн баялаг сургалтын хөтөлбөр боловсруулахад хэрэглэж болох бөгөөд хөтөлбөрүүлийг хиймэл байдлаар зохион байгуулж хувиарлах хэрэгтүй гэж үздэг. Хэрвээ багш нар хүүхдүүдэл тохирсон сургалтын арга барилын хүрээнд зохион байгуулж өгвөл, тэд өөрслэний сонирхлыг үргэлжлүүлэн оролдох явцад уламжлалт хүмүүжлийн тухай ихээхэн суралцаж чадах юм.

Ж.Дьюигийн загварын тухайд анхаарууштай дараах чухал зүйл бий. **Нэгдүгээрт:** түүний загварыг ашиглахдаа яг адил дэс дарааллын дагуу явах ёстой эсвэл явж болохгүй гэж тэрээр хэзээ ч хэлээгүй. Мэдээж багш нар өөрийн сургалтын арга барилдаа тохируулан загварын байрлалыг сэдвийн агуулгын хүрээнд өөрчилж, хэлбэржүүлэхээс гадна шалгах ёстой. **Хоёрдугаарт:** зарим боловсрол судлаачид Ж.Дьюигийн загварын үр дагавруудын үе шатыг нь хасаж багасгадаг. Загварын аль нэгийг үе шатыг орхигдуулвал үр дүн муутай байж болох талтай учир нь хүний байгалиас заяагдсан төрлөх зан араншинг судлаж, түүний үндсэн дээрээс бий болгосон загвар юм.

Хүүхэд эдгээр дөрвөн сонирхлын хүрээнд мэдэж авах ёстой бүхий л мэдлэгээ олж авч чадна гэдэг саналын эсрэг үзэл санаа, шалтгаан бий болох боломжтой. Тухайлбал: Арифметик мэтийн дэс дараалсан хичээлийн хувьд яах вэ? Хэрвээ арифметик дэх бүх дүрэм нь хүүхдийн асуултын тодорхой төлөвлөгөөгөөр хязгаарагласан байх ёстой бол тэдний математикийн мэдлэг томоохон ялгааг харуулна. Энэ дутагдлыг арилгах арга бий юу? гэдэг асуултад хариулт өгөх үүднээс Ж.Дьюи нь боловсролын зорилго, бага сургуулийн боловсролын сэтгэл зүй, өдөөгч хариу онолын алдааны тухай үзэлдээ нэмж өнөөдрийг хүргэл нөлөө бүхий байгаа асуудлын нэг “**бодох үйлдлийн**”<sup>4</sup> загвар гэдгийг боловсруулсан. **Бодох үйлдэл** гэдэг нь ямар нэг зүйл нь тогтсон бус, маргаантай байна гэсэн удаан үргэлжилсэн мэдэрхүйгээс эхлэдэг. Бодох үйлдэл дараах дэс дараалалын дагуу явагддаг. Үүнд:

- Тодорхойгүй нөхцөл байдал
- Нөхцөл байдлыг шүүн тунгаах
- Таамаглалууд
- Үндэслэгээтэй эрэгцүүлэл
- Таамаглалуудыг туршлагаар шалгах тэдгээрээс үр дүнтэйг нь сонгон шалгаруулах
- Шийдвэр

Бодох үйлдлийн эцсийн шат бол бодомж. Ж.Дьюигийн үзлээр бодомж нь “шийдвэр” биш юм. Бодогч өмнөх шийдвэрүүдийн үр дагавруудыг бодож үзэн үр дүнгүүдийг үнэлнэ. Шийдвэр гаргахдаа үр ашигийг тооцож үзэх нь чухал чадвар юм. Бодогчид үйл ажиллагааныхаа явцдаа арга зүй эсвэл тайлбарууд нь илүү сайн болох угүйг бодож үздэг. Мөн танин мэдэсэн мэдлэг нь ирээдүйн нөхцөл байдалд хэрхэн хэрэглэгдэж болох вэ? гэдгийг ерөнхийлөн дүгнэх оролдлого хийдэг. Ж.Дьюи нь практик орчилд соргогоор хандах нь чухал шаардлагуудын нэг бөгөөд эцэс төгсгөлгүй эрэл хайгуул хийх, шинэ бүр цоо шинэ төлөв хандлагыг нээхэд хамгийн их анхаардаг байжээ.

Бодох үйлдэл анализ хийх, хүүхдийн сонирхолын мөн чанараас гадна Ж.Дьюи нь туршлагын тухай үзлээрээ алдартай билээ. Ж.Дьюигийн энэ үзэл баримтлалд бага гэхэд хоёр чухал онцлог бий. Тэдгээрийн нэгдүгээрт: тэрээр экзистенциалист философичдын нэгэн адил юмын утгат чанарын тухай ойголтыг философидоо авч үзсэн. Ж.Дьюигийн хувьд туршлага гэдэг нь идэвхгүй явц эсвэл ямар илрэлгүй зүйл биш юм. Энэ нь хэн нэгэн туршиж өнгөрсөн ямар нэг алдаа дутагдал, түүний утга санааг илэрхийлнэ. Хоёрдугаарт: Ж.Дьюигийн хувьд туршлага гэдэг нь нийгмийн болоод соёлын шинжтэй. Тэрээр нэг удаа туршлагын тухай гол бүтээлээ “Туршлага ба Байгаль”-ийг “Соёл ба Байгаль” гэж нэрлэх байсан юм гэж тэмдэглэн

4. Nel Noddings Philosophy of education (Westview Press., 2006), p.31

хэлж байжээ.

Тэрээр боловсролтой байхад туршилага нь өмнөх туршилагатай холбогдоон эсвэл түүн дээр суурилсан байх ёстой гэж үзэж байсан. Өнөөдөр бид үүнийг орчуулах даа суралцагсад хаана байна тэндээс багиш нар эхлэх ёстой гэж хэлдэг. Гэвч багиш нар мөн өгсөн туршилага нь хаашаа чиглүүлж магад вэ? гэдгийг асуух ёстой. Туршилагад үргэлжлэл байх ёстой. Иймд багиш нар суралцагсадынхаа өмнөх туршилагаас ямар нэг зүйл мэдэж байх ёстой. Улмаар түүнээс өрнөн бий болох шинэ суралцах туршилагыг төлөвлөх ёстой. Хичээлийн сэдэв нь суралцагсадын ирээдүйн хэрэгцээ, сонирхол үр ашигт нийцээн байх ёстой. Боловсролын туршилагад зөвхөн үргэлжлэл байх ёстой төдийгүй, туршилага нь суралцагчид утга учир, үр дүнтэй байх ёстой гэж тэрээр үзжээ.

Ж.Дьюи нь өөрийн сургалт хүмүүжлийн тогтолцоондоо төрөлхийн авьяас чадварыг байнга ашиглаж, туршилага, практикийг үйл ажиллагааныхаа гол зэвсэг болгож байв. Түүний зорилго нь хүмүүжилтэй, ажил хэрэгч, хөнгөн шингэн, чадварлаг, ямар ч үнээр хамаагүй эд баялагт хүрэх чадвартай хүнийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Ингэхдээ туршилт, алдааны арга, төслийн аргыг өргөнөөр ашиглахын зайлшгүй цохон тэмдэглэжээ.

## НОМ ЗҮЙ

1. Ж.Отгонбаяр, Т.Нэмэхжаргал. Хүүхдэд зориулсан философис УБ., 2005
2. Nel Noddings. Philosophy of education. Westview Press., 2006
3. John Dewey. The School and Society. Chicago: University of Chicago Press, 1990
4. John Dewey. The Child and the Curriculum. USA., 1966

## SUMMARY

Dewey demonstrated that the human organism does not merely respond to stimuli from without but actively selects stimuli and responds in ways consonant with its purposes or aims. Also, he said, children do not just imitate, they select. When they imitate, they have adopted certain modes of behavior for their own purposes. Dewey described the fourfold interests of children: making things (construction), finding out (inquiry), expressing themselves artistically, and communicating. Children can learn the traditional disciplines within the framework of these four interests.

According to Dewey, the traditional disciplines turn students into inactivity. It is the material that the teacher already prepared and students have to study it within short-term. So it shows bad influence on students. Within the framework of the fourfold interest of children, students stay in constant motion. Also, the students can lead their ability and talent which they acquired by themselves. As for the teacher, the role of the teacher stays in leading and giving an advice to the students to the right direction of study. So the education must be based on a creative talent or an ability given by nature.